

БАТЛАВ

“БЗӨБЦТС” ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Н.ТАВИНБЭХ

..... оны сарынөдөр

**Компьютер, компьютерийн дагалдах хэрэгсэл, проектор, GPS координат
тодорхойлогч нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн
баримт бичиг**

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/05

БЗӨБЦТС ТӨХК 2019 он.

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр: Компьютер, компьютерийн дагалдах хэрэгсэл,
проектор, GPS координат тодорхойлогч нийлүүлэх
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: ХАН№19/05

Боловсруулсан ҮХН бичгийн дарга:

Б.ГҮРРАГЧАА
/Хангамжийн мэргэжилтэн/

Хянасан ҮХ дарга:

Ж.ГАНБААТАР
/Санхүү хангах үйл ажиллагаа
хариуцсан дэд захирал/

Гишүүд:

Х.ХАНДМАА
/Цалин хөлс, жолоочийн тооцоо
хариуцсан нягтлан бодогч/

Ц.ЭНХБАТ
/Хөндлөнгийн гишүүн

Б.ТУЯА
/Хөндлөнгийн гишүүн/

Хаяг: Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС”
ТӨХК-ийн конторын байр.

Утас: 99020551, 99665151
Факс: 70210167

ХА№19/05 тоот тендерийн урилга

Компьютер, компьютерийн дагалдах хэрэгсэл, проектор, GPS координат тодорхойлогч нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт оролцохыг урьж байна.

Тендерийн баримт бичгийн дагуу холбогдох материалуудыг бүрдүүлж төрийн худалдан авах ажиллагааны цахим системд оруулж бидэнтэй хамтран ажиллахыг хүсье. /Тендерийн баримт бичгийг www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу/

Хаяг: Улаанбаатар хот, Багануур дүүрэг, үйлдвэрийн хэсэг, “БЗӨБЦТС” ТӨХК-ийн конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99665151, 99020551

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан цахим хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, цахим системээр нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

 - (а) Үнийн санал.
 - (б) Нийлүүлэлтийн хуваарь.
 - (в) Техникийн тодорхойлолт.
 - (г) Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материал. /ТШӨХ-ийн ТООЗ 1.1-д заасны дагуу/
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгөөр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**

7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.

7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.

7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар. 2. Үнийн санал. /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгчийн гэрчилгээний хуулбар. НӨАТ төлөгч биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх. 4. 2018 оны нийт борлуулалтын орлого тендерийн төсөвт өртгөөс багагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэнэ/. 5. Тухайн аж ахуйн нэгж шүүхийн ямар нэгэн маргаанд хариуцагчаар оролцож байгаагүй тухай шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт. 6. ШШГЕГ-ын тодорхойлолт. 7. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх. /татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын лавлагааг үндэслэнэ/ 8. Нийлүүлэх бараа материалын техникийн тодорхойлолтыг ирүүлэх. /Захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх/ 9. Тендерийн баримт бичгийг цахимаар авна. 10. Гэрээний тусгай нөхцлийн 4-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 11. Баталгаат засварын хугацааг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. 12. Бараа материал нийлүүлэх хугацаа хуанлийн 10 хоногоос ихгүй байна. 13. Сүүлийн 2 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, мөн ажлын өртөг, хугацаа, байршил, бүрэн гүйцэтгэсэн болохыг тодорхойлсон өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт. Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлж байсан нь тендерээс татгалзах үндэслэл болно. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТӨӨЗ 2.1	<p>Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг:</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн байр, 2-р давхар 202 тоот өрөө Утас:99665151</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү бараа материал нийлүүлэх тендер шалгаруулалт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn цахим хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендер хүлээн авах эцсийн хугацаа: 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 10 цаг 00 минутад.</p>
ТӨӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх хугацаа нь:</p> <p>Цахим тендерийн нээлтийг 2019 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн 10 цаг 30 минутад цахим системээр нээнэ.</p>
ТӨӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

**ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ИЖИЛ ТӨСТЭЙ БАРАА МАТЕРИАЛ НИЙЛҮҮЛСЭН ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх ижил төстэй гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхгүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТОО ХЭМЖЭЭ

1. Барааны техникийн тодорхойлолт:
2. Бараа хүргэх газар: **Улаанбаатар хот, Багануур дүүрэг, 3-р хороо үйлдвэрийн хэсэг БЗӨБЦТС ТӨХК-ийн агуулах.**

БАРАА МАТЕРИАЛЫН НЭР ТӨРӨЛ, ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Компьютер дэлгэцийн хамт	ш	3
2	Зөөврийн компьютер	ш	9
3	Зургийн аппарат	ш	1
4	Телефон аппарат	ш	8
5	Компьютерийн дагалдах хэрэгсэл	ком	3
6	Проектор дагалдах хэрэгслийн хамт	ш	1
7	A3 олон үйлдэлт хувилагч, 2 талдаа хэвлэдэг принтер	ш	1
8	Виркний принтер (Хаяг, шошго хэвлэх)	ш	1
9	GPS координат тодорхойлогч	ш	2

БАРАА МАТЕРИАЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1/ СУУРИН КОМПЬЮТЕР, ДЭЛГЭЦ

Д/Д	Төрөл	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	СУУРИН КОМПЬЮТЕР, ДЭЛГЭЦ	Processor	Intel® core I5-3.6Ghz, 8th generation	ш	3
		Display	19" FULL HD LED		
		Memory	8GB,2666Mhz,DDR4		
		HDD	1TB , 7200rpm, 3.5		
		Other:	Keyboard, Mouse		
		Connecter	USB 2.0, USB 3.0, HDMI, LAN		

2/ ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР

Д/Д	Төрөл	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	ЗӨӨВРИЙН КОМПЬЮТЕР	Processor	Intel® core I5-8250u	ш	9
		Display	15.6" Full HD IPS 1920 x 1080		
		Memory	8GB DDR2 2400MHz		
		HDD	2 TB 5400rpm		
		Graphics	AMD radeon 430 4 GB		
		Other:	Wired Mouse		
		Connecter	USB 2.0 USB-C 3.1 Gen 1/DisplayPort HDMI 2 x USB 3.1 Gen 1 LAN Headphone/microphone combo jack		

3/ ЗУРГИЙН АППАРАТ

Д/Д	Төрөл	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	ЗУРГИЙН АППАРАТ	Resolution	20.20 Megapixels	ш	1
		Sensor size:	(6.2mm x 4.6mm) 60.00x zoom		
		Lens:	60.00x zoom (24-1,440mm eq.)		
		Viewfinder:	EVF / LCD		
		Native ISO:	100 - 1600		
		Max Aperture:	3.3		
		Dimensions:	4.9 x 3.3 x 4.2 in. (125 x 85 x 107 mm)		
		Weight:	19.9 oz (565 g) includes batteries		

4/ ТЕЛЕФОН АППАРАТ

Д/Д	Төрөл	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	ТЕЛЕФОН АППАРАТ	For use with KXT Analog Systems 1 Line LCD 12 Programmable Line Buttons Automatic Redial Hands Free Operation Speakerphone with LED Indicator Hold/Flash Key Mute Button Auto Answer Store Key Message Key Intercom/Conference Key Forward/Do Not Disturb Key (DND) Pause/Transfer Key Volume Control for Speakerphone and Handset Headset Compatibility Wall Mountable	ш	8

5/ КОМПЬЮТЕРИЙН ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

Д/Д	Төрөл	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Компьютерын дэлгэц	23" инч , 1920 x 1080 @60Hz, led, 1 x VGA, 1 x HDMI	ш	3
3	Зөөврийн хард диск	Transcend 4TB StoreJet2.5	ш	1

6/ ПРОЕКТОР, ДАГАЛДАХ ХЭРЭГСЭЛ

Д/Д	Төрөл	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Проектор	Colour Brightness: 3,500 Lumens XGA Resolution Auto Vertical Keystone Correction Optional Wi-Fi Epson iProjection™ 2 x HDMI Connectivity (1 x MHL) Split Screen Maintenance cycle of 6,000/12,000hrs (normal/ECO)	ш	1

7/ АЗ ОЛОН ҮЙЛДЭЛТ ХУВИЛАГЧ, ПРИНТЕР

Д/Д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	<p>Өнгөт олон үйлдэлт хувилагч А4/А3</p> <p>Технологи: KYOCERA, Laser Colour, HyPAS™ solution platform Үйлдэл: Хувилах, сүлжээнд хэвлэх болон сканнердах А4/А3 хэмжээгээр өнгөт болон хар (Факс нэмэлтээр сууна) Хэвлэх хурд: 1 минутанд 25/12 хуудас А4/А3 өнгөт болон хараар Хэвлэх нягтрал: 1,200 x 1,200 dpi, 2bit depth for print quality of 4,800 dpi equivalent x 1,200 dpi Эхний хуудас гарах хугацаа: Хамгийн ихдээ хар 6.4сек өнгөт 8,5сек (халах хугацаа 18сек) Хэмжээ: 602 x 665 x 790 mm Жин: Дунджаар 90кг Санах ой: 4GB RAM + 32GB SSD Орох цаас: 150-sheet multipurpose tray, 52 – 300 g/mI (Banner 135 – 165 g/mI), A6R – SRA3 (320 x 450 mm), Tab paper (136 – 256 g/mI), Banner max. 320 x 1,220 mm; 2x 500-sheet universal paper cassette, 52 – 300 g/mI , upper cassette A6R up to A4R, lower cassette A6R up to SRA3 Хамгийн ихдээ 7,150 sheets А4 хуудас орох боломжтой (нэмэлтээр) Гарах цаасны багтаамж: 500 sheets face-down, max. output capacity 4,300 sheets 2 талаар хэвлэх Duplex as standard supports A6R-SRA3 (320 x 450 mm), 64–256 g/mI Үргэлжлүүлэн хувилах: 1 - 999 Zoom: 25 - 400% Сканнер файлын төрөл: Scan to email, Scan to FTP, Scan to SMB, Scan to USB Host, Scan to box, Network TWAIN, WSD scan Сканнер хэмжээ: А3 хүртэл, өнгөтөөр Сканнер нягтрал: 600dpi хүртэл Холболтууд: 4 x USB 2.0 (Hi-Speed), USB Host 2.0, Fast Ethernet 10Base-T/100BaseTX/1000BaseT, slot for Баталгаа: 2 жил эсвэл 50,000 дардас Тохирох хор: ТК-8349С Toner cyan for 12,000 хуудас ТК-8349Ү Toner yellow for 12,000 хуудас ТК-8349М Toner magenta for 12,000 хуудас ТК-8349К Toner black for 20,000 хуудас</p>	ш	1

8/ ВИРКНИЙ ПРИНТЕР

Виркний принтер нь доор дурдагдах техникийн үзүүлэлт, шаардлагуудыг хангасан байх ба Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгддөг стандартын шаардлагууд, Олон улсын IEC стандартын нөхцөл шаардлагад бүрэн нийцсэн, загварын хувьд ашиглагдан туршигдсан, шинэ багаж байх ёстой. Ашиглалтын заавар Монгол, Англи хэлээр байх.

№	Техникийн үзүүлэлт	Тавигдах шаардлага
1	Тэжээлий хүчдэл	АС 220В 50гц
2	Хэвлэх урт	6-100мм
3	Үсгийн фонт	Латин, кирилл үсэгтэй
4	Дэлгэц	LCD
5	Орчны температур	-20 хэмээс +40 хэм
5	Таслах хутга	Ирний гүнийг тохируулдаг байх
6	Хайрцаг	Зөөж тээвэрлэх бат бөх хатуу хайрцагтай байна
7	Санах ой	Өөр дээрээ 12000 тэмдэгт хадгалах боломжтой байна
8	Холболт	Компютерээс холбогдож ажилдаг байх

9/ GPS КООРДИНАТ ТОДОРХОЙЛОЛГЧ

№	Техникийн үзүүлэлт	Утга
1	Дэлгэцний хэмжээ	3.0" x 2.2" (7.6 x 5.6 cm)-с багагүй
2	Дэлгэцний нягтаршил	480*320 pixel
3	Дэлгэцний загвар	256-color TFT
4	Санах ойлд хадгалах боломжит координатын цэгийн тоо	10000-аас багагүй
5	Хүчдэлийн түвшин	Хувьсах 220 В
6	Давтамж	50 Гц
7	Санах ойлд хадгалах маршрутын тоо	50-аас багагүй
8	Хүлээн авагч	GPS хүлээн авагч
9	Мэдээлэл хадгалах карт	Өөр дээрээ мэдээлэл хадгалах карттай Нэмэлт карт суурилуулж мэдээлэл хадгалах боломжтой байх
10	Ажиллах орчин	Далайн түвшнээс дээш 1300-1500 метрийн өндөрт Өндөрлөг, нам дор болон сүлжээгүй газарт ажиллана.
11	Нэмэлт функц	Autocad болон бусад инженерийн зургийн программ руу координатын цэгийг хөрвүүлж, хуулбарлах боломжтой байх
12	Хэл	Англи, Орос, Герман, Монгол
13	Дагалдах хэрэгслүүд	USB кабель, тэжээлийн кабель, мэдээлэл хуулах кабель, хэрэглэгчийн гарын авлага, Машинд цэнэглэх боломжтой байх Хувьсах 220 В-ын цэнэглэгч Антен, цүнх
14	Антен	Дотоод болон гадаад холболттой байх
15	Баталгаат хугацаа	6 сараас доошгүй

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

2019 оны дүгээр сарын-ны өдөр

БЗОБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу хуанлийн хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | | |
|--|-------|--|
| 1. Шалгах болон турших | 1.1. | Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. | Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх | 3.1. | Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна. |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх | 4.1. | Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно. |
| 5. Баталгаат засварын хугацаа | 5.1. | Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 2 /хоёр/ жил байна. |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах | 6.1. | Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй. |
| 7. Төлбөр | 7.1. | Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 60 /жар/ хоногийн дотор шуурхай хийнэ. |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь | 8.1. | Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө. |
| 9. Алданги оногдуулах | 9.1. | Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. |
| 10. Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах | 10.1. | Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна. |
| 11. Маргааныг шийдвэрлэх | 11.1. | Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)** 1.1. Бараа материалыг ажлын хэсэг томилон шалгаж үзнэ. Ажлын хэсгийн дүгнэлтээр бараа материалыг хүлээн авна.
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)** 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
 - 2) Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
 - 3) Үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)** 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- 4. Төлбөр (ГЕН – 7)** Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн **60 /жар/** хоногийн дотор төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹** 9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн **0,5%**.
- Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн **10%-с** ихгүй байна.